



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит*

Аудитын код: *ДОА-2021/130/СТА-ТШЗ*

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг:
khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэргэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 147

танай _____ -ны № _____ -т

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН
ДАРГА Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Уламжлалт анагаах ухааны төв 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 90.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,579,726.06	55,817,461.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	-
31110	Төгрөг	00.00	-
31120	Гадаад валют	00.00	-
31130	Нэмэлт санхүүжилт	00.00	-
31140	Касс арилжааны банк	00.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	-
3121	Төгрөг	00.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	62,570,126.06	55,817,461.19
351	Түүхий эд материал	59,395,126.06	53,854,761.19
35110	Тусгай зориулалттай материал	51,913,193.00	43,695,254.00
35130	Эм боох материал	7,481,933.06	10,159,507.19
354	Хангамжийн материал	3,175,000.00	1,962,700.00
35410	Бичиг хэргийн материал	1,549,000.00	1,340,600.00
35440	Түлш, шатах тослох материал	550,000.00	120,000.00
35460	Хүнсний материал	1,076,000.00	502,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	527,334,505.62	511,327,508.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	527,334,505.62	511,327,508.52
392	Биет хөрөнгө	527,197,005.70	511,258,758.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	506,188,188.00	506,188,188.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,309,409.40	-33,042,840.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,293,041.65	83,475,941.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-49,402,410.87	-56,356,077.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,528,400.00	24,769,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,212,178.97	-13,878,328.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	938,000.00	938,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-826,624.71	-835,124.67
393	Биет бус хөрөнгө	137,499.92	68,749.88
39301	Програм хангамж	556,000.00	556,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-418,500.08	-487,250.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	589,914,231.68	567,144,969.71
412	Богино хугацаат зээлийн өглөг	00.00	-
4121	Төгрөг	00.00	-
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	00.00	-
41212	Хувь хүмүүст олгосон зээл	00.00	-
41213	Сургалтын төрийн сангийн зээлийн өглөг	00.00	-
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	00.00	-
41215	Монгол банк	00.00	-
41216	Арилжааны банк	00.00	-
41217	Санхүүгийн бусад байгууллага	00.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	589,914,231.68	567,144,969.71
51	Засгийн газрын хувь оролцоо	589,914,231.68	567,144,969.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	408,972,992.00	408,972,992.00
51101	Өмч: - төрийн	408,972,992.00	408,972,992.00
512	Хуримтлагдсан үр дүн	180,175,552.18	157,406,290.21
51210	Өмнөх үеийн үр дүн	180,175,552.18	180,175,552.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-22,769,261.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	765,687.50	765,687.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	589,914,231.68	567,144,969.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	372,679,100.00	430,916,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,370,300.00	13,383,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,370,300.00	13,383,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,370,300.00	13,383,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,370,300.00	13,147,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	235,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	367,308,800.00	417,533,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	254,848,400.00	214,236,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	254,848,400.00	214,236,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	112,249,800.00	203,297,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,249,800.00	203,297,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	378,377,228.90	453,686,161.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,377,228.90	453,686,161.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,643,163.80	446,650,932.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,106,676.38	272,619,761.00
210101	Үндсэн цалин	163,429,999.65	147,849,400.00
210102	Нэмэгдэл	40,074,246.73	86,968,836.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,836,430.00	13,229,500.00
210104	Урамшуулал	16,766,000.00	24,572,025.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,621,824.87	35,854,037.78
210201	Тэтгэврийн даатгал	25,663,818.09	24,939,937.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,833,615.49	2,728,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,502,433.78	2,182,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	278,585.72	545,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,343,371.80	5,457,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,863,132.00	16,717,474.00
210301	Гэрэл, цахилгаан	4,686,562.00	3,857,280.25
210302	Түлш, халаалт	6,760,980.00	7,301,423.75
210303	Цэвэр, бохир ус	3,415,590.00	5,558,770.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,969,068.34	24,907,679.00
210401	Бичиг хэрэг	3,793,280.00	2,719,180.00
210402	Тээвэр, шатахуун	1,150,120.00	2,180,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	777,046.65	720,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	3,173,620.00	1,678,430.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,322,630.00	4,344,369.00
210408	Бараа материал акталсны зардал	11,752,371.69	13,265,700.00
2105	Нормативт зардал	41,513,833.34	57,776,223.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,620,228.34	30,222,270.87
210502	Хоол, хүнс	22,376,485.00	26,807,684.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,517,120.00	746,268.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,496,310.00	15,882,420.00
210604	Урсгал засвар	7,099,310.00	15,882,420.00
2107	Томилолт, зочны зардал	1,579,800.00	411,000.00
210702	Дотоод албан томилолт	1,579,800.00	411,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	3,268,739.00	2,806,440.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	1,050,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,812,627.00	1,630,900.00
210807	Газрын төлбөр	156,112.00	104,040.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	21,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,223,779.87	19,675,897.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	22,223,779.87	19,675,897.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	734,065.10	7,035,229.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	360,000.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	374,065.10	6,935,229.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	374,065.10	6,935,229.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,698,128.90	-22,769,261.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,698,128.90	-22,769,261.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	372,679,100.00	430,681,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,370,300.00	13,147,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,370,300.00	13,147,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,370,300.00	13,147,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,370,300.00	13,147,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	367,308,800.00	417,533,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	254,848,400.00	214,236,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	254,848,400.00	214,236,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	112,249,800.00	203,297,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,249,800.00	203,297,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	370,749,100.00	427,012,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,749,100.00	427,012,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,015,034.90	419,736,970.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,612,201.25	272,619,761.00
210101	Үндсэн цалин	167,560,401.52	147,849,400.00
210102	Нэмэгдэл	39,911,200.00	86,968,836.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,377,099.73	13,229,500.00
210104	Урамшуулал	16,763,500.00	24,572,025.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,123,400.00	35,844,437.78
210201	Тэтгэврийн даатгал	19,803,900.00	24,930,337.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,329,900.00	2,728,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,863,900.00	2,182,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	466,000.00	545,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,659,700.00	5,457,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,863,132.00	16,717,474.00
210301	Гэрэл, цахилгаан	4,686,562.00	3,857,280.25
210302	Түлш, халаалт	6,760,980.00	7,301,423.75
210303	Цэвэр, бохир ус	3,415,590.00	5,558,770.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,679,916.65	10,607,540.00
210401	Бичиг хэрэг	4,106,950.00	2,362,080.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	1,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	777,046.65	720,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,713,820.00	1,778,570.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,382,100.00	3,996,890.00
2105	Нормативт зардал	52,593,066.00	62,439,567.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,523,161.00	32,664,045.00
210502	Хоол, хүнс	23,009,015.00	26,233,784.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,060,890.00	3,541,738.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,127,280.00	18,041,150.00
210604	Урсгал засвар	18,142,290.00	18,041,150.00
2107	Томилолт, зочны зардал	1,579,800.00	411,000.00
210702	Дотоод албан томилолт	1,579,800.00	411,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,436,239.00	3,056,040.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	1,050,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,980,127.00	1,880,500.00
210807	Газрын төлбөр	156,112.00	104,040.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	21,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	734,065.10	7,275,229.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	360,000.00	340,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.00	340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	374,065.10	6,935,229.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	374,065.10	6,935,229.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,930,000.00	3,668,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,930,000.00	3,668,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,930,000.00	3,668,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,930,000.00	3,668,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,930,000.00	3,668,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,930,000.00	-3,668,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,112,174.56	4,112,174.56
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	180,175,552.18	589,914,231.68
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	180,175,552.18	589,914,231.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	180,175,552.18	589,914,231.68
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-22,769,261.97	-22,769,261.97
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	157,406,290.21	567,144,969.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,199,400.0	372,094,434.9	429,943,400.0	423,745,870.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,199,400.0	372,094,434.9	429,943,400.0	423,745,870.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,839,400.0	371,734,434.9	429,583,400.0	423,405,870.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,686,800.0	235,612,201.3	272,853,200.0	272,619,761.0
210101	Үндсэн цалин	167,635,000.0	167,560,401.5	147,849,400.0	147,849,400.0
210102	Нэмэгдэл	39,911,200.0	39,911,200.0	90,352,400.0	86,968,836.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,377,100.0	11,377,099.7	12,474,000.0	13,229,500.0
210104	Урамшуулал	16,763,500.0	16,763,500.0	22,177,400.0	24,572,025.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,123,400.0	29,123,400.0	36,835,200.0	35,844,437.8
210201	Тэтгэврийн даатгал	19,803,900.0	19,803,900.0	25,921,100.0	24,930,337.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,329,900.0	2,329,900.0	2,728,500.0	2,728,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,863,900.0	1,863,900.0	2,182,800.0	2,182,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	466,000.0	466,000.0	545,700.0	545,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,659,700.0	4,659,700.0	5,457,100.0	5,457,100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,863,900.0	14,863,132.0	20,483,800.0	16,717,474.0
210301	Гэрэл, цахилгаан	5,090,400.0	4,686,562.0	5,210,300.0	3,857,280.3
210302	Түлш, халаалт	5,277,500.0	6,760,980.0	7,577,500.0	7,301,423.8
210303	Цэвэр, бохир ус	4,496,000.0	3,415,590.0	7,696,000.0	5,558,770.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10,472,400.0	10,469,316.7	11,290,300.0	10,607,540.0
210401	Бичиг хэрэг	3,369,100.0	3,896,350.0	2,369,100.0	2,362,080.0
210402	Тээвэр, шатахуун	2,284,500.0	1,700,000.0	2,284,500.0	1,750,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,000.0	777,046.7	720,000.0	720,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, аг	2,716,700.0	2,713,820.0	1,916,700.0	1,778,570.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,382,100.0	1,382,100.0	4,000,000.0	3,996,890.0

Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	52,595,500.0	52,593,066.0	62,472,200.0	62,439,567.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,794,900.0	23,523,161.0	32,671,600.0	32,664,045.0
210502	Хоол, хүнс	22,736,000.0	23,009,015.0	26,236,000.0	26,233,784.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,064,600.0	6,060,890.0	3,564,600.0	3,541,738.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,063,200.0	24,057,280.0	21,614,500.0	21,611,050.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,772,000.0	1,674,990.0	3,572,000.0	3,569,900.0
210604	Урсгал засвар	18,291,200.0	19,382,290.0	18,042,500.0	18,041,150.0
2107	Томилолт, зочны зардал	1,584,000.0	1,579,800.0	784,000.0	411,000.0
210702	Дотоод албан томилолт	1,584,000.0	1,579,800.0	784,000.0	411,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х	3,450,200.0	3,436,239.0	3,250,200.0	3,155,040.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.0	240,000.0	1,050,000.0	1,050,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-	1,984,000.0	1,979,500.0
210807	Газрын төлбөр	156,200.0	156,112.0	156,200.0	104,040.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураа	60,000.0	60,000.0	60,000.0	21,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	360,000.0	360,000.0	360,000.0	340,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	360,000.0	360,000.0	360,000.0	340,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.0	360,000.0	360,000.0	340,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	372,199,400.0	372,094,434.9	429,943,400.0	423,745,870.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	372,199,400.0	372,094,434.9	429,943,400.0	423,745,870.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	214,236,500.0	208,040,870.3
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС СА	112,320,000.0	112,249,800.0	203,299,200.0	203,297,300.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,320,000.0	112,320,000.0	203,299,200.0	203,297,300.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,031,000.0	5,370,300.0	12,407,700.0	12,407,700.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,031,000.0	5,370,300.0	12,407,700.0	12,407,700.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	15.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	02.00	02.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (16.00	16.00	16.00	16.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3.Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Батцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-ноос 2021 оны 02 дүгээр сарын 10–ний хооронд Хаан консалтинг Аудит ХХК-ийн Аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Уламжлалт анагаах ухааны төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Европ-монгол уламжлалт анагаах ухааныг хослуулан хүний бие махбодын онцлогт тохирсон уламжлалт монгол эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэх
- Монгол эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх, COVID 19 халдвараас сэргийлэх, тэмцэх, Магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангах бэлтгэл хийж магадлан итгэмжлүүлэх, эрхэм зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Уламжлалт анагаах ухааны төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Уламжлалт анагаах ухааны төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 453,686.1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 9,073.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,769.2 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9.6		-9.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	62,570.1	55,817.5	-6,752.6
Үндсэн хөрөнгө	527,334.5	511,327.5	-16,007.0
Нийт хөрөнгө	589,914.2	567,145.0	-22,769.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	589,914.2	567,145.0	-22,769.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	589,914.2	567,145.0	-22,769.2

Авлагын үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 62,570.1 мянга, тайлант онд урсгал төсвийн хөрөнгөөр 88,802.6 мянга, хандив тусламжаар 235.8 мянган төгрөг буюу нийт 89038.4 мянган төгрөгөөр бараа материал нэмэгдсэн ба 82,289.8 мянган төгрөгийн бараа материалын зарлага, байгууллагын даргын тушаалаар 13,501.5 мянгант төгрөгийн бараа материал акталснаар бараа материалын эцсийн үлдэгдэл 55,817.5 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 615,503.6 мянга, тайлант онд урсгал төсвийн хөрөнгөөр 3,668.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, АИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор 3,245.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна. Үндсэн хөрөнгийн анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасаж нийт үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 511,327.5 мянган төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 567,144.9 мянган төгрөг болж 22,769.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Уламжлалт анагаах ухааны төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 50,225 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт өссөнтэй холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 75,308.9 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материал, бараа үйлчилгээний бусад зардлууд өссөн байна. Энэ нь цалин, НДШ-ийн нэмэгдсэн, бараа материал акталж устгасан зэргээс шалтгаалсан байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 429,943.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 429,943,4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөл зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 429,943.4 мянган төгрөг, нийт зардлыг 429,943.4 мянган төгрөгөөр буюу төлөвлөсөн хэмжээгээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 214,236.5 мянга, эрүүл мэндийн даатгалаас 203,299.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 12,407.7 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ

Гүйцэтгэлээр 208,040.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 203,297.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 12,407.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 423,745.9 мянган төгрөг буюу 98,6 хувьтай байгаа нь цалин, шимтгэл, тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардал хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна.

3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 157 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	35,421.0	1	35,421.0	0.0	0.0	100.0
Зөвлөмж	2	159.1	2	159.1	0.0	0.0	100.0
Нийт дүн	3	35,580.1	3	35,580.1	0.0	0.0	100.0

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,576.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 904.9 төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 32,671.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Худалдан авах болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой 904.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Эмийн тендерийн гэрээг эм ханган нийлүүлэх 3 байгууллагатай хийсэн бөгөөд худалдан авалтыг анхан шатны баримттай тулган шалгаж үзэхэд зарим эмийн үнэ нэгж дүнгээрээ гэрээний үнийг баримтлаагүй боловч нийт дүнгээр нь авч үзвэл гэрээний үнээс доогуур 904.9 мянган төгрөгийн хэмнэлттэй худалдан авалт хийсэн харагдаж байна. Энэ нь төсвийн зардалд хэмнэлт болж харагдаж байгаа боловч тендерийн босго үнийг тогтоож, төлөвлөхдөө зах зээлийн үнийн судалгаа хийгээгүй, төсвийн хэмнэлттэй байх зарчмыг баримтлаагүй, үр дүн багатай, зах зээлийн үнээс өндрөөр төлөвлөж тендер зарласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дэх заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

- 1.1. **Илрүүлэлт:** Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийг 4 удаа зарласан боловч тендер амжилтгүй болсон шалтгааныг судалж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулаагүй, журмын дагуу Сангийн яаманд мэдэгдээгүй гэрээг шууд байгуулсан.
- 1.2. **Эрсдэл:** Хууль журам хэрэгжихгүй байх, тендер шалгаруулалт үр дүнгүй, төсвийн хэмнэлтийн зарчим алдагдах
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.1 30.4.2 34.3 тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА -2021/130/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Уламжлалт Анагаах Ухааны Төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эмийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг хийхдээ төсвийн хэмнэлттэй байх зарчмыг баримтлаагүй, үр дүн багатай гэрээ байгуулж гэрээний үнийг дагаж мөрдөөгүй	904.9	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Батцэцэг Ц.Мөнхтунгалаг
2	Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийг 4 удаа зарласан боловч тендер амжилтгүй болсон шалтгааныг судалж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулаагүй гэрээг шууд байгуулсан.	32,671.6	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Батцэцэг Ц.Мөнхтунгалаг



Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ДҮН	32,576.5			
-----	----------	--	--	--